

Монголын сэтгэгч Лувсанжамц (Угалзын багш, 1885-1962)

“ЦЭЦЭН ТЭНЭГИЙН СУДРЫН ТАЙЛБАР”¹–ААС

(Асрах сэтгэлийг бясалгахуй)

12.Арван хоёрдугаар бүлгийн нэр нь “Хаан Жамбадовын (Асрахуйн хүчит) өглөг өгсөн бүлэг” болой.

Урьдын тэр цагт бидний ханьцашгүй багш Чадагчийн эрхэт бээр бодьсатва явахын цагт Өвчин туссан таван ягчисыг өөрийн биений мах шунхаар баясган цэнгүүлж, ерөөл тавьснаар эцэстээ бурхан болсны дараа тэднийг нөхдийн анхдагч нар болгож, номын рашаанаар цэнгүүлэн зохиож ашдын амгаланд байгуулсан Жамбадов хааны цадиг нь: “Ийн хэмээн би бээр” хэмээхээс “Ийн хэмээн би бээр” хэмээхээс “илт баясвай.” хэмээх болой.”

Энэ нь хар цагаан үйлийн үрийг авч орхихуйн ёс лугаа зохилдсон ёс цаазаар хаан төрийг номын дагуу тэтгэхийн тус эрдэм хийгээд цаанаа ёс цааз лугаа тааруулалгүй төр тэтгэхийн гэм буруу зэргийг “Судрын аймгийн дээд Алтангэрэл”-ийн “Шастрын бүлэг”-ээс үзүүлсэн дагуу байх ёс ба бодь сэтгэл, магад гарахуйн санаа зэргээр баттай тангараглаж сахиснаар хязгаалахгүй, хааны хууль цаазын дагуу арван цагаан буны ёсыг сахихад ч орон үест нажод өвчин, ад, тотгор зэргүүд үл дийлдэх ба ялгамжаатай орон лугаа барилдваас хойшдоо гэтлэхүй нирвааны авьяас тогтох ба зөвхөн хорлол зовлон эдлэж амьдарч буй тэдгээр амьтан нь урьд нь амьтан хорлож явсны үрийг амсаж зовж байгаа шиг амсах шалтаг зохилдож

өөрт хорлол хөнөөл гарах нь үргэлжлэх бөгөөд бусдад хорлол гарахад баясаж байсны шалтагаар үйлдэл зохилдох үйлээр хожим үргэлжид зовлонг татдаг ёсыг санаж бурхан багшийн цадиг лугаа зохилдуулж энэрч нигүүлсэж үйлдэх учиртай ёс болон Бурхан бодьсатва нарын чандарласан үрэл, их дээд егүүзэр нарын таван рашаан болон долоон төрлийн бодьсатвын үрэл, рашааныг хүртэх зэргийн тус эрдэм ба, Хайдүв тамжидчэнбу бээр:

“Итгэлт таны нигуурын амьсхал төдий нь ч

Хамаг амьтныг боловсруулах үндэс болох тул

Хоёр буяны явдал бусдыг хэлээд яах вэ”

хэмээсэн мэт Дээд төрөлхтөн нарын эрдэм ном төдийгүй, мах шунх тэргүүтэн тунгалаг цөв, хөлс хүртэл амьтныг боловсруулж гэтэлгэхийн үндэс болдог ба,

“Авихисамья”(Илт онохуйн чимэг)-гаас:

“Бодь хийгээд шүтээн тахил ямагт”

хэмээсэн мэт хаана оршсон орон газар,

¹ Орчуулсан Т.Булган

Энд толилуулан буй Лувсанжамц аграмбийн туурвисан “Цэцэн тэнэгийн судрын тайлбар” (“Цэцэн тэнэгийн судраас айлдсан цадигаас хожмын суралцагч нарт сургамж болгож найруулсан буюу Авч орхихыг тодруулагч ухааны нүдийг нээгч” хэмээгдэх оршвой”) бол угтаа Бурхан багшийн айлдсан хожим ард олны дунд “Үлгэрийн далай”(the Ocean of Narratives,) “Шулуун онолт”(Siluguun onol-tu kemegdeku sudur) “Цэцэн тэнэгийг судар” (the Wise and Foolish sutra) зэрэг олон нэрээр дэлгэрч ялангуяа буддын гүн ухааны сэтгэлгээний суурь онол болох үйлийн үрийн онол түүний гүн нарийн учир утгыг Буддха Шагжа Мүни багшийн өөрийн туулж өнгөрүүлсэн амьдралын туршлага, мэдлэг, цадиг түүхээр “үлгэрлэн үзүүлсэн”(the Jatakas) тэрхүү гайхамшигт судрын тайлбар бөгөөд зөвхөн намтар түүх төдий биш гүн ухааны сургаал,сэтгэлгээ, онолын тайлбар болж чадсан Монгол сэтгэгчийн бүтээл билээ.Уг тайлбартаа Угалзын багштан судрын нэрийн талаар: “Цэцэн тэнэг” хэмээхийн учир нь энэхүү судрыг сонсоод үйлийн үрд сэтгэлээр итгэвэл цэцэн хэмээх, гурвантаа сонссон ч үйлийн үрд сэтгэлээр үл итгэвээс тэнэг мөн хэмээсэн утга гэж олон мэргэдээс дамжиж ирсэн үг ярианаас уламжилжээ “ хэмээн өгүүлсэн байна.

баринтаг хувцас, мутар, бойв зэргээр хүрсэн тоос хүртэл амьтны ариун орон болдог тул бусдыг хэлэхийн хэрэг юун.

“Бодьчарияаватара”-гаас:

“Байгаа бүхнээ үр сэлтгэй нь

Амьтан бүхнээ өгөх сэтгэлээр”

хэмээн айлдсан мэт Их бодьёадва нар нь өөрийн бие төгс эдлэл, буйны язгуур сэвтээ бусдад өгөх ба өгөлг өгсөн үр буянаа хртэл тэдэнд зориулдаг ба,

“Мадхьямакааватара” –гаас:

“Өгөхтүн хэмээх дууг хэзээ сонсонгуут

Бодьсадва нарт амгалан төрөх, тийн
Чадагч нар

Амарлингуйд орших зуур амгалан
өгч чадахгүй тул

Хамаг бүгдээ өгөхийг хэлээд яах
вэ.” хэмээн айлдсан мэт.

Тийнхүү өглөг өгөхдөө дээдийн дээдээр баясдаг эрдэм зэргийг бэлгэдсэн намтар болой.

Тэрхүү бүлэг төгссөнийг үзүүлэх нь: “Хаан Жамбадовын (Асрахуйн хүчит) өглөг өгсөн арван хоёрдугаар бүлэг” болой.

(Үзэл онолыг харьцуулахуй) **13.Арван гуравдугаар бүлгийн нэр нь: “Зургаан багшийг номхотгосон бүлэг” болой.**

Амьтан бүхнийг ялгалгүй аврашч орон, үнэхээр хуурмаггүй багш, шалгарсан төрөлхтөн, ханьцашгүй шагжа мүни бээр амьтан хүнийг буруугаар удирдах, хуурмаг гутамшигт оруулах буруу номын ёсыг заагч хуурамч багш нарыг номхотгож, хуурмаг буруу үзлийн номыг няцааж, буруу мөрд орсон доорд хувьт нарын буруу үзлийг орхиулж амьтан хүнийг зөв зүгийн үнэн мөрд эрхлэн хөтөлж даруйд болон алсын тус амгаланд байгуулан зохиосон намтар нь: Ийн хэмээн би бээр хэмээхээс буянд баясах болой “хэмээх хүртэл болой.

Өөрийн эрдэм хэдий чинээ дээш ахих тусам алин ачаар нь тэрхүү эрдмийг олгосон багш чухаг дээдэст сүсэглэх, бишрэх сэтгэл улам

арвижих учиртайг үзүүлжээ. Тэрхүү эрдэм нь “Судар” –аас:

“Сүжиг үгүй хүмүүнд

Цагаан зүгийн ном үл төрөх бөгөөд

Хөрөнгө нь галд шатсан

Хөх ногоотой адил болой.”

хэмээсэн мэт сүсэгт суурилж төрөх хэрэгтэй тул инагш чинагш дээш арвидаж үйлдэх мөн. Сүсэг байхгүй бол эрдэм сурч байна гэж ярих, сонсох зэргийн эрдэм сураагүй хэрнээ сүсэг бишрэлд дадав гэж ярих төдийгээс цааш хэтрэхгүй болой. Чингэхдээ бага төрөлхтний үед чухаг дээд гурвын мөн чанар, чадал эрдэм зэргийг ёсчлон мэдээд авралыг одуулснаар шашинд орно хэмээсэн байна. Гэтэл тэр мэт чадаагүй тул авралыг олох арга байхгүйд хүрнэ. Тиймээс урьдийн үйл болон хувь төгөлдөр байх буюу эдүгээ буяны садан болон сайн нөхрөөр эзлэгдэх, өвдөх зовохын зовлонгоос айх буюу даруйдын хэрэг тусыг бүтээх буюу номыг сонсох, санах зэргээр үйлдэхийн шалтгаанаар өөрийн хувь болон чухаг дээдийн ач хурахын хүчээр авралыг одуулах санаа бага сага төрж эхэлдэг байна. Буяны садныг шүтэж дээдийн номыг сонсох ба түүнээ ёсчилон бүтээхийг ухаарч өөрийн сэтгэлдээ нотлон буулгадаг байна. Сонссон номын гол утга өгүүлсэн утга хоёрыг нийлүүлж ном дагуу санах ба сайн нөхөртэй нөхөрлөх зэргийн шалтгаанд шамдваас чухаг дээд гурвын адистэд орших болно. Улмаар сүсэг, ухаан улам арвижих зэрэг нь авралыг одуулахын хүч улам нэмэгдэхтэй шүтэн баридахуйн жамт тул тэр мэтэд шамдаж үйлдэх мөн.

Бурханы шашинтай уулзахад бэрх бөгөөд өнө удахгүй үхэх ба үхээд хаашаа одох нь өөрийн эрхээр бус, муу заяанд одсон хойно хэрхэн зовлон эдлэх зэргийн ёсыг санаж айж мэгдэх ба түүнээс аврах чадал чухаг дээдэд байгаа гэдгийг шалгадаг ухаанаар магадлаагүй ч гэсэн ерөнхий ухаарал олж авах нь сонсголонгоос гарах ухаанд суурилсан сэтгэл итгэмжлэлийн сүсгээр авралыг одуулахад хүрнэ. Айх, аврахын хоёр шалтгаан бүрдүүлж, бага төрөлхтний зөв авралыг олох бөгөөд шашны үүдээх орох мөн.

Эдүгээ дунд төрөлхтний авралд хүрээгүй тул гурван ертөнцийн дээд

доод алив оронд төрөвч үргэлжид гурван зовлонгийн аль нэгээр нэрвэгдэх ба худагийн эргүүлэг мэт эргэлдэн эцэстээ гурван муу заяанаас үл хэтэрх тул хорвоогоос гэтлэхгүй бол зовлонгоос гэтлэхгүй гэдгийг ухаарч, магад гарахуйн санааны үүднээс авралыг эрж хайх болно.

Чингээд *“Тийн тайлбар”*-аас: “Тэрээр өт хорхойны тоог мэдэх

Бидэнд хэзээ ч чухал биш” хэмээсэн мэт Бурхан бээр сав шим ертөнцийн хэлбэр дүрс, эрт урьдын түүх гарвацийг айлдсан зэрэг нь үлгэр үзүүлсэнээс бус гол тус хэрэг нь биш л дээ. Гол хэрэг нь юунд байгааг *“Тийн тайлбар”* –аас:

”Авах болоод орхих орон ямагтыг

Арга билгийн үүднээс сайтар магадлаж

Гол утганаа хуурмаг үгүй тулд”

хэмээсэн мэт зовлонгоос гарахын гэтлэхийн арга дөрвөн үнэнийг авч орхихын ёсыг үзүүлсэнд байгаа тул Түүнийг магадлан ухаарснаар магад тонилохуйг /нирваан/ заасан арга ухаан буюу бурханы зарлиг нь өгүүлэгдэхүүн утгадаа хуурмаггүй болохыг магадлах ба түүгээр жишин Дээрх шастраас: Бусдыг ч даган жиших мөн” хэмээсэн мэт Өндөр язгуурын арга ухааныг заасан багш хуурмаггүй үнэн гэж сэтгэл итгэмжлэн эндүүрэггүй авралыг заагч бурхан нь шалгарсан дээд гэгээрсэн төрөлхтөн бөгөөд бодит аврал болсон түүний заасан ном болон Авралыг бүтээх хань нөхөр, тэрхүү номыг ёсчилон анхааран авсан хуврага гэсэн гурван чухаг дээд дор аврал одуулах болсноор дунд төрөлхтөн лүгээ нийтийн авралыг олно. Түүнээ суурилж дөрвөн үнэн, шүтэн барилдахуйг бясалгаж тодорхой ухааралд хүрдэг. *“Авхидхармакоша”* –гаас:

“Гурван үнэнийг үзвээс шагшабад хийгээд

Номыг мэдэж сүсэг олох

Мөрийг илт мэдвээс бурхан хийгээд

Түүний хуврага нугууд дор ч”

хэмээн айлдсан туланхдугаар үр “үргэлжид оршихийн үрийг олохын тулд чухаг дээд гурвыг мэдэж сүсэг олох хэрэгтэй тул сүсэг болоод хүндэтгэх бишрэхийг сэтгэл үлэмж

илүү болох ёсыг үзүүлсэн болой.

Чингээд “Тэр оронд Зогжэд тэргүүтэн” хэмээхээс хуран үйлдсэн бүдээр тэнгэр хүмүүнд төрвэй.” хэмээхийн утга нь аврал болж таарахгүй тааруухан багш нар, аврал аврал бусаа үл ялгах муу хувьт тэнэг шавь нар, хар зүгийн тэнгэр сахиус зэргүүд нь гэм буруутан буюу ичгүүрийн орон болох хийгээд Ашдын авралд зохистой зөв багш ба авралд бариваас зохист ухаан төгөлдөр хувь сайт шавь нар, цагаан зүгийн тэнгэр сахиус сэлтийн эрдэм хийгээд сонин гайхамшигт намтар цадигууд хийгээд олз хүндлэлд шүлэнгэтэх шунал, бусдын сайн сайханд үл тэсэж, хомхойтох атаархал, өчүүхэн эрдэм төдийг олчихоод дээдийг олсон гэх бардам омог, бусдын эрдэм болон өөрийн хэмжээгээ мэдэхгүй их мунхаг сэтгэлт нарт өчүүхэн эрдэм олсон ч тус болохоос уршиг тарих хэмээн тээршааж үзэх зэргийг *“Магтваас зохист магтаал”* –аас:

“Таны номоос гадагш зүглэсэн

Мунхагийн харалган төрөлхтөн

Сансрын үзүүрт хүрсан ч

Дахин зовлнд учирч зовлонгоо бүтээх“

хэмээсэн мэт энэ насны үзэгдэл төдийгэр барахгүй “Юуч үгүй” хэмээх орноос доошхи тэнгэр сэлтийн ертөнцөөс шуналаа буцаах ба рид хувилгаан зөн мэдэл зэргийн эрдэм хичнээнийг олсон ч, чухаг дээд гуравт авралд барьж чадаагүй бол жич дахин унаж хэмжээлшгүй зовлон амсах ёсыг мөн дээрх *“Магтаал”* –аас:

“Таны номыг даган одвоос

Самадийн бодит сууурийг олоогүй байсан ч

Шумнасын нүдийг бүлтэлзүүлэн

Сансрын зовлонг буцааж үйлдэх”

хэмээн айлдсэн мэт Төдий чинээ эрдэм олоогүй ч чухаг дээдийг авралд барьж чадваас шумнасын нүдийг бүлтэлзүүлэн шумнас болон эрлэгийн гараас гэтлэж, сансраас тонилж нирвааны хутагийг олж чадах ёс болон эхрдэм болоод буян багадаад өргөвч дээш одохгүй байх, эрдэм буян нь ихдээд даравч доошлохгүй байх ёсон, бурханы эрдэм огторгуй лугаа сацуу тул бусдаар жишиж үл болохын

ёс, Вишнү тэнгэрүүд вүшнүгийн рид хувилгаанаас нирвааныг оллоо хэмээн өгүүлдэгтэй адил өөрөө бясалгал бүтээл үйлдээгүй хэрнээ бусдын рид хувилгаан төдийхнээс нирвааныг олох байхгүй ч, бурхан тэргүүтний рид хувилгааны хүчнээс сүсэг, эрмэлзэл, шагшабад, соносох, санах, бясалгах гурвын эрэмбээр өндөр язгуур, эцэст нирваанд хүрэх хүртэлх ёс болон “Мөрийн дээд зүрхэн”-ээс:

“Их аюул түүнээс аварч үйлдэхийг нь
Ертөнцийн их тэнгэрүүд чадахгүй тул
Алин шүтвээс хуурмаггүй байх тэр нь
Аюул бүхнийг тэвчсэн, бусдыг
гэтэлгэх арганаа мэргэн,

Ойр холд үл баригч, зөвхөн авралын
орон чухаг дээд гуравт

Сэтгэлээр итгэж аврал одуулахаар
шамдах ба,

Тэдгээрийн тус эрдмийг ухаарч
сэтгэлдээ нийлүүлж

Зөвшөөрсөн болон хорьсон
суртгаалийг доройтуулалгүй
үйлдсүгэй.

Тэр мэтээр чадахыг үлэмжийн тэнгэр
багш та бээр

Их нигүүлсэхүйн рашаан усаар
адистэдлэхтүн”

хэмээн айлдсан мэт анхааран авах хэрэгтэй ёс болон бурхан бодьсатва нарын гурван нууцын санаанд багташгүй зохионгуйг нягтлан мэдэх хэрэгтэй ёсыг ч бэлгэдэн үзүүлсэн намтар болой.

Чингээд “ Сүгжан нинбу хаан бээр хоёр өвдөгөө газарт сөгдүүлээд” хэмээхээс илт баясах болой” хэмээх хүртэл нь: Ялж төгөлдөр нөгчигсэн түүний мутар бойв зэрэг нь хүрдэн тэмдэг т тэргүүтэн гучин хоёр бэлгэтэй, наян найраг зэрэг лагшингийн эрдэмтэй, тэдгээр шинж бүтэхийн нийт ба нийт бусын үндэс болон өөрөө буян бүтээхийн дээр бусдыг буянд байгуул бал үлэмж болохын ёс хийгээд нүглийн шалтгаан болохоор бол ертөнцийн ямарч ч сайн сайхан болов орих хэрэгтэй ёс, Буян бүтээхээр хичээж явахад шумнасууд зэтгэр хийхээр хичээх ба, Арван зүгийн бурхад зэтэрггүй болгохоор хичээх

ёс зэргийг “Шэрчэн до” (Билгийн чинадад хүрэхүй судар) –ноос дэлгэрэнгүй айлдсан ёс болон, өвөр бусдыг арилжсан их бодьсатва нар амьтны тусын тулд мөн бол аюус тамын их гал руу орохдоо ч өчүүхэн эмээлгүй орох нь ч халуун наранд энэлсэн их заан линхуйн далайд орохтой адил баясах ёс ба буян нүглийн үйл магадтай, ихэд арвижих, шим нь үл шамшаагдах тул бие хэл сэтгэлийн үйлийг сахихаар шамдах хэрэгтэй билээ. Нүглийн боловсрох үрийг амсаж эдлэхээс гарах буюу наминчлаад арилгаж болох ч, үйлдэх үндэс зохилдох үр аоилагагүй байхад тэр мэтийн үйлнээ дахин дахин орох ба Амсан үндэс зохилдсон үр аоилагагүй байхад зовлонгийн үйлдэгдэл хэвээр байх тул, “Мөрийн дээд зүрхэн”-ээс:

“Суртгаалийн эрхэм болон аюулын
бодит аврал нь

Хар цагаан үйлийг авч орших ёс мөн тул

Үйл үр солигдохгүй, магадтай, ихэд
арвиждаг зэрэгт

Сэтгэл итгэмжилж арван хар зэрэг

Бүдүүн нарийн бүгдийг тэвчиж, хааяа
нэг

Нарийн гүэл уналаар халдвал жич засал
болон

Дөрвөн хүчний аньс бүрдсэн
наминчилгаар түргэнээ арилгах бөгөөд

Сайн шүтээний ач үр бүтэх бат нотыг
олсугай”“

Тэр мэтээр чадахыг үлэмжийн тэнгэр багш
та бээр

Их нигүүлсэхүйн рашаан усаар
адистэдлэхтүн”

хэмээн айлдсан мэт анхааран авах хэрэгтэй ёсыг бэлгэдэн үзүүлсэн намтар болой. Тэрхүү бүлэг төгссөнийг үзүүлэх нь: : “Зургаан багшийг номхотгосон арван гуравдугаар бүлэг” болой.